ХОНКОНГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ ОНЦГОЙ БҮСИЙН ДЭЭД ШҮҮХ АНХАН ШАТНЫ ШҮҮХ

2018 ОНЫ 6083 ДУГААР ДАМПУУРЛЫН ХЭРЭГ

ХОЛБОГДОХ ЭТГЭЭД:	ЛИ ШАОМИНГ	Хариуцагч
НЭХЭМЖЛЭГЧ:	DILIGENT MYRIA LIMITED	Нэхэмжлэгч

Шүүх бүрэлдэхүүн: Дээд шүүхийн орлон ажиллаж буй шүүгч, ахлах өмгөөлөгч Уильям Вонг, шүүх хуралдаанаар

Шүүх хуралдааны огноо: 2019 оны 11 дүгээр сарын 6

Шийдвэрийн огноо: 2019 оны 11 дүгээр сарын 15

ШИЙДВЭР

1. 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Diligent Myria Limited (цаашид “Нэхэмжлэгч” гэх) нь 2018 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн хуулийн дагуу хүргүүлсэн төлбөрийн шаардлага (цаашид “Хуулийн дагуух шаардлага” гэх)-д үндэслэн Ли Шаоминг (цаашид “Хариуцагч” гэх)-ийг дампууруулах хүсэлт (цаашид “Хүсэлт” гэх) гаргасан.

2. Хүсэлт нь 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн эвлэрлийн гэрээ (цаашид “Эвлэрлийн гэрээ” гэх)-нээс үүссэн өрөнд үндэслэсэн бөгөөд уг гэрээгээр Хариуцагч нь бусад үүргийн зэрэгцээ 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдөр Нэхэмжлэгчид 5,000,000 ам.доллар (цаашид “Хүсэлтийн үндэслэл болсон өр” гэх) төлөхөөр тохиролцсон (Эвлэрлийн гэрээний 3 дугаар зүйлийн 1(1), (2) дахь заалтыг үзнэ үү).

3. Хариуцагч Эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурсан талаар маргаангүй. Гэвч Хариуцагч нь Эвлэрлийн гэрээнд албадлагын улмаас гарын үсэг зурсан, эсхүл наад зах нь албадлагын улмаас гарын үсэг зурсан эсэх талаар шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байгаа бөгөөд энэ нь Эвлэрлийн гэрээг хүчингүй болгуулах боломжтой болгоно гэж тайлбарласан.

ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗАРЧМУУД

4. Холбогдох эрх зүйн шалгуур нэгэнт тогтсон. Хүсэлтийн үндэслэл болсон өрийн талаар бодитой, хангалттай үндэслэл бүхий маргаан байгааг хангалттай нарийн тодорхой үйл баримтын нотлох баримтаар Шүүхэд нотлох үүрэг Хариуцагчид ногдоно. Хариуцагч нь үйл баримтын талаар зарим маргаантай асуудлыг дурдаад, тэдгээрийг шүүх хуралдаанаар шийдвэрлэх ёстой гэж тайлбарлах төдий нь хангалтгүй.

5. Хүсэлтийг эсэргүүцэхэд тавих босго шалгуур нь илүү өндөр түвшний шаардлагыг хангах ёстой гэсэн шүүхийн тайлбарууд байдаг (тухайн үед шүүгч байсан Рожерсийн *Re ICS Computer Distribution Ltd* [1996] 1 HKLR 181 хэргийн 183G–J дэх хэсгийг үзнэ үү). Практикт энэ илүү өндөр шаардлагыг тодорхой хэргийн үйл баримтад хэрэглэхэд хэрхэн өөр үр дүнд хүрэхийг би олж харахгүй байна. Саяхан *Re Leung Cherng Jiunn (debtor)* [2016] 1 HKLRD 850 хэрэгт тухайн үед Давж заалдах шатны шүүхийн шүүгч байсан Кван 27(4) дэх хэсэгт дараах байдлаар өгүүлсэн:

> “Энэхүү ялгааг үл харгалзан, Английн сүүлийн үеийн хоёр шийдвэрт тэмдэглэснээр, хоёр нөхцөлд хэрэглэгдэх босго шалгуур ерөнхийдөө төстэй гэж хэлэх нь зүйтэй. Хэрэв бодитой, хангалттай үндэслэл бүхий маргаан байгаа гэсэн үндэслэлээр хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол хялбаршуулсан журмаар шийдвэр гаргуулах боломж маш бага байна. Хариуцагчид болзолгүйгээр, эсхүл түүний татгалзлыг эргэлзээтэй гэж үзвэл болзол тавьж, нэхэмжлэлийн эсрэг өөрийгөө хамгаалах зөвшөөрөл олгох нь хамгийн магадлалтай. Харин хариуцагч иймэ зөвшөөрлийг болзолгүйгээр эсхүл болзолтойгоор авсан тохиолдолд хүсэлтийг хангах магадлал маш бага байна. *Markham v Karsten* хэргийн [45] дахь хэсгийг үзнэ үү. *ICS Computer* хэргийн 183E–F дэх хэсэгт шүүгч Рожерсийн өгүүлсэн зүйл үүнээс өөр утга илэрхийлээгүй.”

6. Миний үзэж байгаагаар, гол асуудал нь дампуурлын болон/эсхүл компанийг татан буулгах ажиллагааны хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд тохиромжгүй болгохуйц бодитой, ач холбогдол бүхий үйл баримтын маргаан байгаа эсэхийг Шүүх үнэлэхэд оршино. Ийм нөхцөлд хүсэлтийн үндэслэл болсон өр хүчин төгөлдөр эсэхийг шүүх хуралдаанаар бүрэн шалгах шаардлагатай. Гэвч хүсэлтийн үндэслэл болсон өрийн суурь үндэслэлд хамаарахгүй захын асуудал болон/эсхүл үйл баримтын маргаан нь ихэнхдээ анхаарал сарниулах шинжтэй бөгөөд уг өрийн талаар бодитой, хангалттай үндэслэл бүхий маргаан байгаа эсэхийг тогтооход хамааралгүй.

ХЭРЭГТ АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ ҮЙЛ БАРИМТ

7. Британийн Виржиний арлуудад байгуулагдсан Prosper Huge Limited компанийг Хариуцагч 100 хувь эзэмшдэг (цаашид “Prosper Huge” гэх). Prosper Huge болон Нэхэмжлэгчийн хооронд 2009 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан гэрээгээр Prosper нь Prosper Huge-ийн 833 ширхэг хувьцааг 4,998,000 ам.доллараар худалдах, Нэхэмжлэгч нь худалдан авахаар тохиролцсон (цаашид “2009 оны Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ” гэх).

8. 2009 оны Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний 4.2 дахь заалтаар Prosper Huge нь Камбож дахь 16 уурхайн ашигт малтмал олборлох эрхийг худалдан авч, эдгээр эрхийг дор хаяж 1 тэрбум ам.доллараар худалдах замаар хөрөнгө босгохоор зорихоор заасан. Хэрэв 24 сарын дотор олборлох эрхийг дээрх үнээр худалдаж чадаагүй бол Нэхэмжлэгч нь анхны хөрөнгө оруулалтад нь 25 хувийн дотоод өгөөжийн түвшин өгөх үнээр 833 ширхэг хувьцааг эргүүлэн худалдан авахыг Prosper Huge-ээс шаардах эрхтэй байв.

9. 2009 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Prosper Huge болон Нэхэмжлэгч нь мөн “буцаан үл цуцлах батлан даалт” (цаашид “Батлан даалт” гэх)-д гарын үсэг зурсан. Уг баримт бичигт Хариуцагч нь 2009 оны Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний 4.2 дахь заалтын дагуу Prosper Huge-ийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг батлан даахаар тохиролцсон гэж заасан. Хариуцагчийн хэлснээр, тэрээр Батлан даалтад хувь хүний хувиар бус, зөвхөн Prosper Huge-ийн эрх бүхий төлөөлөгчийн хувиар гарын үсэг зурсан байна.

10. 2014 онд Prosper Huge нь нэмэлт гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-нд гарын үсэг зурсан бөгөөд уг гэрээний 3 дугаар зүйлд “Ноён Ли нь 2014 оны 2 дугаар сарын 20-ны дотор нийт 32.483 сая ам.долларын төлбөрийг хоёр хэсэгчлэн төлөхөөр тохиролцсон” гэж зааж, төлбөрийг Caslin Holdings Ltd (цаашид “Caslin” гэх), Нэхэмжлэгч, Goodwill Return Limited (цаашид “Goodwill” гэх) болон Brightest Group Limited (цаашид “Brightest Group” гэх)-д төлөхөөр тусгасан.

11. Хариуцагч нь 2014 оны Нэмэлт гэрээнд мөн хувь хүний хувиар бус, зөвхөн Prosper Huge-ийн эрх бүхий төлөөлөгчийн хувиар гарын үсэг зурсан гэж дахин мэдэгдсэн.

12. Prosper Huge, Caslin, Нэхэмжлэгч, Goodwill, Brightest Group болон Shengjie (Beijing) Investment Consulting Company Limited (цаашид "Shenghie" гэх)-ийн хооронд 2015 оны 5 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан гэрээ (цаашид "2015 оны Нэмэлт гэрээ" гэх)-гээр Shengjie нь худалдан авагч Shengjie болон худалдагч Prosper Huge-ийн хооронд байгуулсан худалдах, худалдан авах гэрээний дагуу Prosper Huge-д төлөх ёстой төлбөрийн орлогыг Caslin, Нэхэмжлэгч, Goodwill болон Brightest Group тус бүрд шууд шилжүүлэхээр тохиролцсон.

13. Хариуцагч нь 2015 оны Нэмэлт гэрээнд мөн хувь хүний хувиар бус, зөвхөн Prosper Huge-ийн эрх бүхий төлөөлөгчийн хувиар гарын үсэг зурсан гэж дахин мэдэгдсэн.

14. 2018 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Хариуцагч Ван Лэтянь ("LT Wang") болон бусадтай уулзсан. Ню Шимин ("Niu")-ий мэдүүлэгт Ли нь "Prosper Huge Limited-д хийсэн тус тусын хөрөнгө оруулалттай холбоотойгоор Нэхэмжлэгч болон Brightest Group Ltd-д төлөх өрийг батлан даагчийн хувиар эргүүлэн төлөх хувийн үүргээ дахин баталгаажуулсан" гэж дурджээ. Ню нь Brightest Group Limited-ийн хувьцаа эзэмшигч юм.

15. Хариуцагчийн мэдүүлгээр, талууд 2009 оны Хувьцаа худалдах, худалдан авах гэрээг хэлэлцэхээр уулзсан бөгөөд тэрээр зөвхөн "Prosper Huge-ийн төлөөлөгчийн хувиар хэлэлцүүлэг, хэлэлцээнд оролцсон" учир "хувь хүний хувиар аливаа үүрэг хүлээснээ хүлээн зөвшөөрөөгүй" байна.

16. 2018 оны 2 дугаар сарын 6 болон 8-ны өдрүүдэд Жан Жяньфэн ("Zhang") (Ван Лэтяний үүсгэн байгуулсан компанийн дэд ерөнхийлөгч бөгөөд энэхүү хэрэг үүсэхэд хүргэсэн асуудлуудаар Ван Лэтяньд тусалж байсан хүн) нь Хариуцагчийн байгуулсан Lung Ming Mining Company Limited (цаашид "Lung Ming" гэх)-ийн хуулийн ерөнхий зөвлөх Ван Юаньхэн ("Wang")-д төрөл бүрийн гэрээний төслийг цахим шуудангаар илгээсэн.

17. 2018 оны 2 дугаар сарын 9-ний өдөр Хариуцагч, Ван Лэтянь, Ли Бин болон Ню нар Хариуцагч хувь хүний хувиар өр төлбөрөө төлөх хуваарийг тусгасан санамж бичиг (цаашид "Санамж бичиг" гэх)-т гарын үсэг зурсан нь ач холбогдолтой.

18. 2018 оны 2 дугаар сарын 10-ны өдөр Жан нэмэлт гэрээний төслүүдийг YH Wang-д цахим шуудангаар илгээсэн.

19. 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр Жан болон YH Wang нар цахим шуудангаар үргэлжлүүлэн харилцсан. YH Wang нь Хариуцагчийн гарын үсэг зурсан суурь хөрөнгө оруулалтын гэрээнүүдийг Жангаас хүссэн боловч Жан тэдгээрийг YH Wang-д өгөхөөс татгалзсан.

20. 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Ван Лэтянь, Ли Бин, Ню, Шюн Янь болон Жан (цаашид "Таван этгээд" гэх) нар Ваньчай дахь Central Plaza барилгын 68 дугаар давхарт байрлах Lung Ming-ийн оффист (цаашид "Хариуцагчийн оффис" гэх) өглөөний 11 цагийн орчимд очсон бөгөөд оройн 10–11 цаг хүртэл яваагүй.

21. Таван этгээдийг Хариуцагчийн оффисоос гарах үед Хариуцагч нь Эвлэрлийн гэрээг оролцуулан дөрвөн гэрээнд гарын үсэг зурсан байв.

22. Хариуцагчийн байр суурь нь тэрээр Эвлэрлийн гэрээнд албадлагын улмаас гарын үсэг зурсан гэхэд оршино. Тэрээр Эвлэрлийн гэрээг хүчингүй болгуулах сонголт хийсэн. Иймд уг гэрээг албадан биелүүлэх боломжгүй гэж үзэж байна.

23. Эвлэрлийн гэрээнд дараах нөхцөл, заалтууд тусгагдсан:

(1) Удиртгалын 1 дэх хэсэгт 2009 оны Хувьцаа худалдах, худалдан авах гэрээг дурдан, Ли нь буцаан үл цуцлах батлан даалт гаргасан гэж заасан;

(2) Удиртгалын 2 дахь хэсэгт Нэхэмжлэгч, Goodwill, Brightest Group болон Well Victory тус бүрийн оруулсан үндсэн хөрөнгө оруулалтын дүнг тусгасан;

(3) 1 дүгээр зүйлд Эвлэрлийн гэрээ нь өмнөх бүх гэрээг орлож, тэдгээрийн оронд үйлчлэхээр заасан; мөн

(4) 2 дугаар зүйлд Хариуцагч нь 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор бусад талд 51.67 сая ам.доллар (үүнээс үндсэн төлбөр 37.48 сая ам.доллар, хүү 14.19 сая ам.доллар) төлөхөөр заасан.

ДҮН ШИНЖИЛГЭЭ

Албадлага

24. Албадлагад хамаарах эрх зүйн зарчмууд нэгэнт тогтсон.

25. Нэгдүгээрт, албадлага хэмээх зүй бус үйлдэл нь хоёр бүрэлдэхүүнтэй. Эхнийх нь хохирогчийн хүсэл зоригийг албадан захирах хэмжээнд хүрсэн дарамт. Хоёр дахь нь уг дарамт хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй байх явдал юм. Дарамт нь хууль зүйн хувьд зөвшөөрөгдөх эсэхийг хоёр талаас нь шалгах ёстой. Нэгдүгээрт, дарамтын шинж чанар; хоёрдугаарт, уг дарамтаар дэмжиж буй шаардлагын шинж чанар. (*Universe Tankships v International Transport Workers Federation* [1983] 1 AC 366 хэргийн 400–401 дэх хуудсанд лорд Скарманы өгүүлснийг үзнэ үү.)

26. Хоёрдугаарт, хүний эсрэг албадлага гэдэг нь тухайн хүнийг гэрээ байгуулах эсхүл төлбөр хийхэд хүргэхийн тулд түүний амь нас, эрүүл мэнд, эрх чөлөөнд заналхийлэхийг хэлнэ. Амь нас, бие махбодод заналхийлээгүй байсан ч хууль бусаар хорих эсхүл хорихоор хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй байдлаар заналхийлэх нь албадлага байж болно. (Enonchong, *Duress, Undue Influence and Unconscionable Dealing*, 3 дахь хэвлэл, §§5-002–5-003-ыг үзнэ үү.)

27. Гуравдугаарт, хүний эсрэг албадлагын тохиолдолд гомдол гаргагч нь уг дарамт гэрээ байгуулах болсон нэг шалтгаан байсныг л нотлоход хангалттай. Хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй дарамт нь гэрээ байгуулах шийдвэрт үнэн хэрэгтээ огт нөлөөлөөгүй гэх нотлох баримт байхгүй бол шүүх уг дарамтын улмаас гэрээ байгуулсан гэж дүгнэнэ. Үүнээс үзэхэд хүний эсрэг заналхийллийн тохиолдолд гомдол гаргагч нь маргаж буй гэрээг байгуулахаас өөр бодит боломж байгаагүйг нотлох шаардлагагүй. (*Duress, Undue Influence and Unconscionable Dealing*, §§4-003–4-024-ийг үзнэ үү.)

28. Дөрөвдүгээрт, эдийн засгийн албадлагад хамаарах эрх зүйн зарчмуудыг шүүгч Ж. Лам *Zebra Industries (Orogenesis Nova) Ltd v Wah Tong Paper Products Group Ltd* [2016] 1 HKC 213 хэргийн 234–237 дахь хуудсанд дараах байдлаар товч нэгтгэсэн:

(1) Эдийн засгийн дарамтыг наад зах нь хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй гэж тодорхойлж болох бөгөөд энэ нь нэхэмжлэгчийг холбогдох гэрээг байгуулахад хүргэсэн чухал шалтгаан болсон бол уг дарамт нь албадлагад тооцогдохуйц байж болно;

(2) Дарамт нь хууль бус заналхийлэл агуулсан эсхүл шударга ёсонд илт харш үйлдэлд хүрсэн бол хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй. Гэхдээ энэ нь зөвхөн эдгээр төрлөөр хязгаарлагдахгүй;

(3) Хууль зүйн хувьд зөвшөөрөгдөхгүй дарамт байсан эсэхийг тогтоохдоо шүүх олон хүчин зүйлийг харгалзан үзнэ. Үүнд гэрээг бодитоор зөрчсөн эсхүл зөрчихөөр заналхийлсэн эсэх; дарамт үзүүлсэн гэх этгээд шударгаар эсхүл шударга бусаар үйлдсэн эсэх; хохирогчид дарамтад автахаас өөр бодитой, хэрэгжихүйц сонголт байсан эсэх; хохирогч тухайн үед эсэргүүцсэн эсэх; мөн тэрээр гэрээг баталгаажуулж, түүнд тулгуурлахыг зорьсон эсэх хамаарна.

29. Нотлох баримтыг нягтлан авч үзээд, ноён Чэний чадварлаг, сайшаалтай тайлбаруудыг үл харгалзан, албадлагын асуудлаар бодитой маргаан байгааг нотлох үүргээ Хариуцагч биелүүлээгүй гэж би үзэж байна. Энэ хэргийн үйл баримтаас үзэхэд албадлагад тулгуурласан татгалзлын үндэслэлд бодит агуулга байхгүй нь Шүүхэд нэн тодорхой байна.

30. Нэгдүгээрт, Эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурахаас ердөө дөрвөн өдрийн өмнө Хариуцагч Санамж бичигт сайн дураараа гарын үсэг зурсан нь ач холбогдолтой. Түүний 3 дугаар зүйлд Хариуцагч нь 2018 оны 3 дугаар сарын 31-нээс 2018 оны 6 дугаар сарын 30-ны хооронд Ван Лэтянь, Ли Бин болон Ню нарт нийт 77,948,800 ам.долларыг эргүүлэн төлөхөөр тохиролцсоныг тодорхой заасан. Тухайн үед Хариуцагч хувь хүний хувиар хариуцлага хүлээхгүй гэж мэдэгдээгүй. Хариуцагч нь Prosper Huge-ийн эцсийн өмчлөгч бөгөөд 100 хувийг эзэмшдэг тул Нэхэмжлэгч Prosper Huge-ийн өр төлбөрт түүгээр хувийн батлан даалт гаргуулахыг хүсэх нь зүйн хэрэг юм. Түүнчлэн тэрээр Санамж бичигт аливаа албадлагагүйгээр, сайн дураараа гарын үсэг зурсан нь эргэлзээгүй. Санамж бичигт компаниуд нь бус, хувь хүмүүс гарын үсэг зурсан нь ач холбогдолгүй. Учир нь гол асуудал нь Хариуцагч өөрийн хувийн үүргийг сайн дураараа хүлээн зөвшөөрсөн явдал юм.

31. Хоёрдугаарт, Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэний тайлбарласнаар, Хариуцагч өөрт нь илүү чухал, яаралтай шийдэх асуудал байгаа гэж хэлсний дараа Таван этгээд “[түүнтэй] өр төлбөр барагдуулах гэрээг байгуулах хүртэл [түүнийг] явуулахгүй” гэж хэлсэн тухай Хариуцагч мэдүүлжээ. Хариуцагч “баримт бичгүүдийг уншихаас татгалзсан бөгөөд [Таван этгээд] [түүнийг] хурлын өрөөнөөс гаргахгүй байсан” гэжээ.

32. Гомдол гаргаж буй эдгээр үйлдэл нь ямар ч байдлаар хууль бусаар саатуулах эсхүл хорих үйлдэлд хүрэхгүй гэж би үзэж байна. Тухайн гэх үйл явдал Хариуцагчийн өөрийн оффист болсон. Хэрэв тэрээр өөрийн оффисоос үнэхээр гарахыг хүссэн бол хамгаалалтын ажилтан болон/эсхүл өөрийн ажилтнуудыг дуудах бүрэн боломжтой байв. Тэрээр Хонконгийн цагдааг дуудаж болох байсан.

33. Түүнчлэн Хариуцагч Эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурсны дараа эсэргүүцэл илэрхийлсэн гэх нотлох баримт алга. Тэрээр 2018 оны 2 дугаар сарын 13-наас хойш Эвлэрлийн гэрээг хүчингүй болгуулахыг ч оролдоогүй. Албадлагын үндэслэлээр Хуулийн дагуух шаардлагыг хүчингүй болгуулах хүсэлт гаргаагүй. Түүний эсрэг Хүсэлт гаргасны дараа л тэрээр үүнийг татгалзлын үндэслэл болгон гаргаж тавьсан.

34. Хариуцагч өөрийн хүсэл зоригийн эсрэг Эвлэрлийн гэрээнд албадан гарын үсэг зурсан ч ажил хэргийн найрсаг харилцаагаа хадгалахыг хүссэн байж болохыг түүнийг төлөөлсөн ноён Чэн тайлбарлав. Үйл явдлын ийм хувилбарт итгэх боломжтой гэж би үзэхгүй байна. Хэрэв Хариуцагч үнэхээр албадлагын улмаас, эсхүл хувийн аюулгүй байдалд нь заналхийлсэн, эсхүл түүний хэлснээр дагаж мөрдөнө гэж сүрдүүлсэн учир Эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурсан бол анхны боломж гармагц, наад

зах нь урвуу худалдан авалтын хэлцэл (цаашид “RTO хэлцэл” гэх)-ийн дараахан уг гэрээг хүчингүй болгуулахыг оролдоогүй гэх нь итгэхийн аргагүй байна.

35. Гуравдугаарт, Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэн Таван этгээд Хариуцагчийн оффист дор хаяж 10 цаг байсан бөгөөд энэ 10 цагийн эцэст Хариуцагч Эвлэрлийн гэрээг оролцуулсан дөрвөн гэрээнд гарын үсэг зурсан гэж тайлбарлав. Энэ нь түүнийг хүсэл зоригийнх нь эсрэг оффист саатуулсан гэх Хариуцагчийн байр суурийг дэмжинэ гэжээ. Би үүнтэй санал нийлэхгүй. Арилжааны хэлэлцээ болон/эсхүл эвлэрүүлэн зуучлалд ихээхэн хугацаа зарцуулах нь түгээмэл. Бүр үүр цайтал үргэлжилж болно. Зөвхөн энэ нөхцөл байдал нь тохиролцсон аливаа хэлцэл болон/эсхүл гэрээг албадлагын үндэслэлээр хүчингүй болгуулах боломжтой болгохгүй. Хариуцагч нь ямар ч хуульч байлцуулаагүй, 10 цаг үргэлжилсэн сунжирсан хэлэлцээний дараа л дөрвөн гэрээнд гарын үсэг зурсан нь гэрээнүүдэд албадлагын улмаас гарын үсэг зурсан гэх дүгнэлтийг дэмжинэ гэж ноён Чэн тайлбарласан. Энэ тайлбарыг няцаахад надад эргэлзээ алга. Хэрэв эсрэгээр нь үзвэл ширүүн хэлэлцээний үр дүнд байгуулсан олон арилжааны хэлцлийг хялбархан хүчингүй болгуулж болох болно. Энэ нь зөв байж таарахгүй.

36. Дөрөвдүгээрт, Хариуцагчийн гарын үсэг зурсан 2014 оны Нэмэлт гэрээнд тэрээр Нэхэмжлэгчийг оролцуулан бусад талд буцаан үл цуцлах хувийн батлан даалт гаргасан тухай тодорхой мэдэгдэл орсныг мөн анхаарах нь чухал. Уг баримт бичиг хятад хэлээр бичигдсэн бөгөөд тэрээр сайн дураараа гарын үсэг зурсан.

37. 2015 оны Нэмэлт гэрээнд мөн Хариуцагч нь Нэхэмжлэгчийг оролцуулан бусад талд үндсэн төлбөр болон хүүг хоёуланг нь эргүүлэн төлөхөөр тохиролцсоныг тодорхой заасан. Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэн тэрээр хувь хүний хувиар бус, Prosper Huge-ийн төлөөлөгчийн хувиар гарын үсэг зурсан гэдэгт ихээхэн ач холбогдол өгсөн. Миний үзэж байгаагаар энэ нь хамааралгүй. Харин 2014 оны Нэмэлт гэрээ болон 2015 оны Нэмэлт гэрээний аль алинд Хариуцагч сайн дураараа гарын үсэг зурж баталгаажуулсан үйл баримтын тодорхой мэдэгдлүүд агуулагдаж байгаа нь чухал юм. Хариуцагч бол туршлагатай бизнес эрхлэгч. Гэрээний баримт бичгүүдэд буруу үйл баримт тусгагдсан байсан бол тэрээр тэдгээрт өөрчлөлт оруулах санал гаргахгүй байсан гэхэд итгэхэд бэрх.

38. Нэхэмжлэгчийг төлөөлсөн ноён Огийн тайлбарласнаар, бүх үйл явдал Хариуцагчийн оффист болсон байхад Таван этгээд түүнийг хурлын өрөөнөөс гаргахгүй гэж заналхийлж чадсан гэх нь өөрөө үнэмшилгүй юм. Хариуцагчийн оффисын ажилтнууд болон уг оффисын барилгын менежментийг хариуцдаг ажилтнуудын тоо Таван этгээдийн тооноос олон байсан байх магадлалтай бөгөөд тэд Таван этгээдийг Хариуцагчийн оффисоос гаргах хууль ёсны эрхтэй байв. Хэрэв Таван этгээд үнэхээр зөвшөөрөлгүйгээр байр эзэлж байсан бол Хариуцагч тэднийг гаргуулахаар Хонконгийн цагдаагаас тусламж хүсэж болох байсан. Энэ бүхэн ердийн эрүүл ухаанд нийцэж байгаа бөгөөд би санал нэг байна.

39. Түүнчлэн Хариуцагч Эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурахгүй бол Хонконгоос явахгүй гэсэн Таван этгээдийн гэх заналхийллийг заналхийлэл гэж үзэхэд бэрх гэдэгтэй би санал нэг байна. Таван этгээд Хонконгт байх төдий нь Хариуцагчид заналхийлэл болно гэж үзэхэд бэрх юм.

40. Эцсийн дүндээ, нотолгоогүй мэдэгдлээс өөрөөр Хариуцагчийг хууль бусаар саатуулсан эсхүл хувийн аюулгүй байдалд нь заналхийлсэн гэдгийг нотлох хангалттай нарийн тодорхой үйл баримтын нотлох баримт алга. Санамж бичигт гарын үсэг зурсан явдлыг оролцуулан хэргийн нийт нөхцөл байдлыг авч үзэхэд хүний эсрэг албадлагад тулгуурласан татгалзлын үндэслэлийг үнэмшилтэй гэж үзэхгүй байна.

41. Эдийн засгийн албадлагын тухайд, асуудлыг Таван этгээдийн сэтгэлд нийцүүлэн шийдвэрлэхгүй бол “[Ли]-гийн ажиллаж буй RTO хэлцлийг тасалдуулахын

тулд Хонконгийн хөрөнгийн бирж (SEHK)-д мэдээлэл хүргүүлнэ” гэж тэд заналхийлсэн хэмээн Хариуцагч мэдүүлсэн. RTO хэлцэл нь Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй аж ахуйн нэгж оролцсон урвуу худалдан авалтын хэлцэл байсан. Тус хэлцлийн Хариуцагчид өгөх үнэ цэнэ нь Эвлэрлийн гэрээгээр хүлээсэн өр төлбөрөөс нь хавьгүй их байсан гэж тайлбарлажээ.

42. Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэн Жангаас YH Wang-д илгээсэн 2018 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн цахим шууданг дурдсан. Түүнд Жан Хариуцагчийг 2018 оны 10 дугаар сарын 10-ны дотор төлбөр хийхийг шаардсан бөгөөд биелүүлэхгүй бол Ван Лэтянь шүүхийн ажиллагаа эхлүүлнэ гэжээ. Жан Ван Лэтяний тал “нээлттэй захидал бэлтгэж байгаа бөгөөд Литэй холбоотой маргааны дэлгэрэнгүйг бусад хөрөнгө оруулагчид болон SEHK зэрэг байгууллагад ил болгоно” гэж мэдэгдсэн.

43. Шүүх хуралдаан дээр Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэн дээрх цахим шуудан нь эдийн засгийн албадлага болохгүй гэдгийг зүй ёсоор хүлээн зөвшөөрсөн. Хариуцагчийн зээлдүүлэгчид шүүхийн ажиллагаа эхлүүлэх, эдгээр маргааны дэлгэрэнгүйг бусад хөрөнгө оруулагчид ил болгох эрхтэй. Үүнийг эдийн засгийн албадлага гэж үзнэ гэдгийг төсөөлөхөд бэрх.

44. Нэхэмжлэгчийг төлөөлсөн ноён О Хариуцагч нь Таван этгээд RTO хэлцлийг хэрхэн тасалдуулахаар заналхийлсэн талаар хангалттай нарийн тодорхой үйл баримтын нотлох баримт ерөөсөө гаргаагүй гэж тайлбарласан. Жишээлбэл, RTO хэлцэлд Таван этгээдийн мэддэг, SEHK-д илчилж болох хууль бус эсхүл зүй бус зүйл байсан уу? Түүнчлэн Таван этгээдийн хийсэн зүйл нь 2018 оны 9 дүгээр сарын 28-ны цахим шууданд дурдсантай адил байсан бол албадлага болсон эсэхийг Шүүх авч үзэхэд ч хангалттай үндэслэл болохгүй гэж тайлбарласан. Би үүнтэй санал нэг байна.

45. Ноён О цааш нь, Хариуцагч Эвлэрлийн гэрээний нөхцөлийг биелүүлээгүй байхад ч Таван этгээд SEHK-д ямар нэгэн мэдээлэл огт хүргүүлээгүй нь баримт тул эдийн засгийн албадлага байсан гэх мэдэгдэлд итгэх боломжгүй гэж тайлбарлав.

46. Түүнчлэн Хариуцагч зөвхөн 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдөр төдийгүй уг өдрөөс өмнөх болон дараах өдрүүдэд Хонконгт өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй солиситор YH Wang-аас бие даасан зөвлөгөө авч байсан.

47. Гол нь, албадлагын аль аль хэлбэрийн талаарх мэдэгдлийг тухайн үед үйлдэгдсэн баримт бичгүүдтэй нь уялдуулан авч үзэж, шинжлэх ёстой гэж би үзэж байна.

48. Нэгдүгээрт, Эвлэрлийн гэрээнд 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдөр гарын үсэг зурсан. Үүнээс ойролцоогоор долоон сарын дараа буюу 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр HY Wang нь Хариуцагчийн нэрийн өмнөөс эвлэрлийн нэмэлт гэрээний төслийн гурван хувийг Жанд цахим шуудангаар илгээсэн. Эвлэрлийн нэмэлт гэрээний төслийн удиртгалд Эвлэрлийн гэрээг тухайлан дурдаж, түүнд тулгуурласан байв.

49. Эвлэрлийн нэмэлт гэрээний төслийн агуулгыг Хариуцагч нягтлан үзэж, санал өгөх нөхцөлтэй болохыг цахим шууданд тодорхой дурдсан гэсэн ноён Чэний тайлбарыг би хүлээн зөвшөөрч байна. Гэвч HY Wang нь Хариуцагчийн нэрийн өмнөөс Эвлэрлийн гэрээг дурдан, түүнд тулгуурласан гэх баримт өөрөө уг гэрээг албадлагын улмаас байгуулсан гэх байр суурьтай огт нийцэхгүй.

50. Хоёрдугаарт, 2018 оны 6 дугаар сард Хариуцагчийн компаниудын нэг болох Business Universe Limited нь Ли Бинд 650,000 ам.доллар төлсөн. Ноён Чэн үүнийг Хариуцагчийн өмнөөс хийсэн төлбөр биш гэж тайлбарласан. Гэвч Эвлэрлийн гэрээний дагуу өрийн зарим хэсгийг эргүүлэн төлөхөөс өөр ямар зорилгоор Хариуцагч өөрийн

компаниар дамжуулан Ли Бинд ийм төлбөр хийлгэх шаардлагатай байсан талаар үнэмшилтэй тайлбар алга.

51. Түүнчлэн Ван Лэтяний компанид 400,000 юанийн төлбөр хийсэн нь 2019 оны 2 дугаар сарын (Хүсэлтийн ажиллагаа эхэлсний дараах) WeChat-ийн харилцааны бичлэгээр нотлогдож байна. Уг төлбөр Эвлэрлийн гэрээтэй холбоогүй гэж Хариуцагч мэдэгдсэн боловч өөрийн компаниуд дээрх 400,000 юанийг хүлээн авах өөр шалтгаан байгаагүйг Ван Лэтянь баталсан.

52. Гуравдугаарт, 2018 оны 2 дугаар сарын 6-наас 12-ны хооронд Жан эвлэрлийн гэрээний төслүүдийг YH Wang-д илгээсэн. 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр YH Wang өөрөө Эвлэрлийн гэрээ болон бусад гэрээнд маргааш нь буюу 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдөр гарын үсэг зурахыг хүлээн зөвшөөрсөн. 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Жангаас YH Wang-д илгээсэн бүх цахим шуудан нь гэрээний төслүүдэд өөрчлөлт, засвар оруулсныг харуулж байна. Энэ нь Таван этгээд аливаа өөрчлөлт оруулахыг зөвшөөрөөгүй гэх Хариуцагчийн мэдэгдэлтэй зөрчилдөнө. Эдгээр бүх бодит үйл баримт нь Хариуцагчийн албадлагын талаарх байр суурьтай нийцэхгүй.

53. Дөрөвдүгээрт, 2019 оны 1 дүгээр сарын байдлаар Хариуцагч Эвлэрлийн гэрээ болон бусад баримт бичгийн дагуу төлөх үлдэгдэл өрийг барагдуулна гэдгээ Шюн Юнаар дамжуулан Таван этгээдэд дахин баталсаар байсан. Шюн Юны 2019 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн WeChat зурваст, Хариуцагч өөрийнх нь өмнөөс үг дамжуулахыг хүссэн бөгөөд өр төлөхөд зориулж мөнгө бэлтгэхээр чадах бүхнээ хийж байгаа, мөн шүүхэд эсэргүүцэл гаргаж байгаа нь зөвхөн хугацаа хожих зорилготой гэж тэмдэглэгдсэн байна.

54. Бүрэн гүйцэд авч үзэх үүднээс тэмдэглэхэд, Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэн Эвлэрлийн гэрээ нь хариу төлөөсөөр (consideration) хангагдаагүй гэх маргаан гаргаагүй нь оновчтой байв. Ноён Огийн тулгуурласан, талуудын нийтлэг ойлголтод үндэслэн өмнөх байр сууриасаа буцахыг хориглох зарчим (estoppel by convention)-ын тухайд, энэ нь гол асуудал болох Эвлэрлийн гэрээг албадлагын үндэслэлээр хүчингүй болгуулах боломжтой эсэх талаар бодитой маргаан байгаа эсэхийг шинжлэхэд нэмэр болохгүй гэсэн Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэний тайлбартай би санал нэг байна. Ямар ч тохиолдолд, Хариуцагч нь 2000 оны Хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу Prosper Huge-ийн хүлээсэн өр төлбөрийг хувь хүний хувиар батлан даасан гэх Нэхэмжлэгчийн байр суурийг дэмжих тухайн үеийн бичгийн нотлох баримт хангалттай байгаа гэж би үзэж байна.

ШИЙДВЭРЛЭХ НЬ

55. Дээр дурдсан бүх үндэслэлээр дараах шийдвэрийг гаргаж байна:

(1) Хариуцагчийг дампуурсанд тооцсугай;

(2) Хариуцагч нь Хүсэлттэй холбоотой болон түүнийг дагалдан гарсан зардлыг Нэхэмжлэгчид талуудын хооронд нөхөн төлүүлэх зардлын зарчмаар (party to party basis) төлөх тухай урьдчилсан захирамж (costs order nisi) гаргасугай. Зардлын хэмжээг талууд тохиролцоогүй бол шүүхээр хянан тогтоолгосугай. Талууд энэхүү шийдвэрийн өдрөөс хойш 14 хоногийн дотор уг захирамжийг өөрчлүүлэх хүсэлт гаргаагүй бол зардлын тухай урьдчилсан захирамж эцэслэн хүчин төгөлдөр болно.

56. Эцэст нь, Нэхэмжлэгчийг төлөөлсөн ноён О болон Хариуцагчийг төлөөлсөн ноён Чэн нарт тус Шүүхэд үзүүлсэн тустай дэмжлэгийнх нь төлөө талархал илэрхийлье.

(Уильям Вонг, ахлах өмгөөлөгч)
Дээд шүүхийн орлон ажиллаж буй шүүгч

Нэхэмжлэгчийн өмгөөлөгч: Li & Partners-ийн даалгавраар оролцсон ноён Николас О

Хариуцагчийн өмгөөлөгч: Livasiri & Co-ийн даалгавраар оролцсон ноён Дэвид Чэн

Дампуурлын асуудал эрхэлсэн албан ёсны захиран зарцуулагчийг шүүх хуралдаанд оролцохоос чөлөөлсөн.